



МИК ХОЛДИНГ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 4 сарын 29 өдөр

Улаанбаатар хот

1. ХУРЛЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хурал зарласан огноо: 2024/03/18

Хурлын төрөл: Ээлжит

Хурлын хэлбэр: live-р дамжуулан хуралдав.

Хурал болсон огноо, цаг: 2024.04.29-ны өдрийн 11:00 цагт

Хурал болсон газар: МИК-ийн байранд

Хурлын дарга: Чулуундоржийн Хашчулуун

Хуралд оролцсон хувьцаа

эзэмшигчид:

№	Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн овог	Хувьцаа эзэмшигчдийн нэр	Хувьцаа эзэмшигчийн регистер	Энгийн хувьцааны тоо ширхэг
1		КАПИТРОН БАНК ХХК	2677377	210,631
2		ЧИНГИС ХААН БАНК	2698072	61,639
3		ХАС БАНК	2578697	210,621
4		ТӨРИЙН БАНК ХХК	5341469	486,951
5		ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК	5251494**	1,097,953
6	НЯМДАВАА	ЭРДЭНЭЧИМЭГ	МИ71011606	10
7		НЕКСУС ФИНАНС ИНВЕСТМЕНТ ХХК	6091202	117,379
8		ХХ Банк	2635534	2,070,932
9		СИ И СИ ГРУПП ХХК	5727138	488,750
10		СИ ЭН БИ КОНСАЛТИНГ	6466257	2,608,480
12	ХҮРЭЛ	МАРГАД-ЭРДЭНЭ	ЛЮ87072239	1
13		ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК	5479932	1,232,785
15	ЖАДАМБА	МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК ХХК	5461626	3,081,955

Хурлаар асуудал:	хэлэлцсэн	1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай; 2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай; 3. ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай; 4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурлын 22/02 дугаартай тогтоолыг хүчингүй болгох тухай; 5. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай; 6. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай; 7. ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай.
Хуралд оролцсон албан тушаалтан:		• Б.Гантулга, Гүйцэтгэх захирал; • Х.Маралмаа, ТУЗ-ийн ажлын албаны хуульч; Тооллогын комисс: • Б.Болортуяа, “МИК ОССК” ХХК-ийн Хянан нийцүүлэлтийн газрын захирал; • М.Буяндалай, “МИК ОССК” ХХК-ийн СУГ-АПУХ-ын ахлах шинжээч • Б.Тулга МТХ-Программ хөгжүүлэлтийн хэлтсийн программист • “Эрнэст энд Янг Аудит Монголия” ХХК • Партнер Д.Мандахбаяр, • Менежер М.Ундрал
Хурлын ирц:		98.41 хувь

ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТАЛААРХ ТЭМДЭГЛЭЛ

Ч. Хашчулуун:	“МИК Холдинг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисс хурлын ирцийг танилцуулна уу.
Б.Болортуяа:	Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн ээлжит хуралд урьдчилан бичгээр 15004,286 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг 15 хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар саналаа ирүүлсэн нь нийт саналын эрх бүхий 15,246,891 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчдийн 98.41%-ийн ирцтэй байгаа нь хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг хүчин төгөлдөр гэж үзлээ.
Ч.Хашчулуун:	Сайн байцгаана уу, “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 98.41 хувийн ирцтэйгээр эхэлж байна. “МИК Холдинг” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 24/07 дугаартай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тогтоолын дагуу тус хурал эхлэхэд бэлэн боллоо. Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагч та бүхэндээ Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулахад бэлэн боллоо. Украины дайн, БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн удаашралт, дефляци зэрэг асуудлууд гарсан ч МИК дотоодын болон гадаадын зах зээлд идэвхтэй ажиллаж, дотоодын зах зээлд үйл ажиллагаагаа тэлж, олон улсын зах зээлд ажиллах туршлагатай болж, олон улсын түвшинд ч хөрөнгө оруулагчдын итгэлийг олж байна. Хэлэлцэх асуудлын дагуу өнөөдрийн хуралд компанийн 2023 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийсэн “Эрнэст энд Янг Аудит Монголия” ХХК-ийн төлөөлөл оролцож байна. Та бүхэн асууж тодруулах зүйл байвал аудитын компаниас асуух боломжтой. Хэлэлцэх асуудлыг дарааллын Б.Гантулга захирлыг урьж байна.
1 дүгээр асуудал:	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай
Б.Гантулга:	Хувьцаа эзэмшигчид та бүрэнд энэ өдрийн мэндийг хүргэе. 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчид хүргүүлсэн материалын дагуу 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх тайланг танилцуулав.
Ч.Хашчулуун:	Б.Гантулга захиралд баярлалаа. 2023 оны санхүүгийн тайланг “Эрнэст энд Янг Аудит Монголия” ХХК-ийн менежер М.Ундрал танилцуулна. Таныг урьж байна.
М.Ундрал:	Сайн байцгаана уу, Бид МИК Холдинг ХК болон түүний охин компаниудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Группийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн нэгтгэсэн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн

	гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ. Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Группийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)-өөс баталж гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)-ын дагуу материаллаг алдаагүй, бодитой толилуулсан байна. Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”-ийн дагуу Группээс хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна. Аудитын онцгойлсон асуудлууд гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжээр тухайн тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудлууд юм. Эдгээр асуудлуудыг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь анхаарч, аудиторын дүгнэлт өгөхдөө авч үзсэн бөгөөд бид уг асуудлуудын талаар тусдаа дүгнэлт гаргадаггүй болно. Аудитын онцгойлсон асуудал нэг бүрийг бид хэрхэн авч үзсэн талаарх тайлбарыг дор өгөв. Дүгнэлтийн Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт дурдсан үүрэг хариуцлагууд болон эдгээр асуудлуудтай холбоотой үүрэг хариуцлагыг бид бүрэн биелүүлсэн. Үүний дагуу бид нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээнд тохирсон аудитын горимуудыг гүйцэтгэсэн. Дор дурдсан асуудлыг анхаарч үзэхдээ гүйцэтгэсэн горимуудыг багтаасан аудитын горимуудын үр дүн нь энд хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад өгсөн бидний аудитын дүгнэлтийн үндэслэл болно. Баярлалаа. 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаад Төлөөлөн удирдах зөвлөл Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлантай танилцаад дараах дүгнэлтийг гаргасан. “МИК Холдинг ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, дугаар №24/06, 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдөр, Улаанбаатар хот, Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах тухай, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалт, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.7.15 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийг тус үндэслэн тогтоох нь : 1. “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийн гаргасан 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй. 2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй. 3. Энэ тогтоолын 2-т заасан санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэн байгууллагад хүргүүлэн хувьцаа эзэмшигч болон олон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн ажлын алба (Г.Саруул)-нд үүрэг болгосугай. 4. Энэ тогтоолын 2-т заасан тайлангуудыг ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийн хамт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж зохих шийдвэр гаргуулахыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргал даалгасугай.
Ч.Хашчулуун:	
2 дугаар асуудал:	Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай
Ч.Хашчулуун:	Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйл Ногдол ашиг хуваарилах тухай болон “Ногдол ашгийн бодлого”, Олон улсын зах зээлд гаргасан Бондын нөхцөлийн гэрээг үндэслэн “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 24/01 дугаартай тогтоолоор 2024 онд ашиг хуваарилахгүй байхаар гэж шийдвэрлэсэн байна.
3 дугаар асуудал:	ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай
Ч.Хашчулуун:	2024 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчид хүргүүлсэн материалын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны тайланг танилцуулав.
4,5 дугаар асуудал:	Тогтоол хүчингүй болох тухай, Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Ч.Хашчулуун:

Компанийн тухай хуульд заасны дагуу компанийн оршин байгаа газрын хаягийг түүний ерөнхий захиргаа байршин байгаа газраар тодорхойлно гэж заасан.Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу /15160/, Д.Сүхбаатарын талбай гудамж, 11 тоот хаягт байрлах Монголын Ипотекийн Корпорацийн байранд “МИК Холдинг” ХК-ийн ерөнхий захиргаа байрлан үйл ажиллагаа явуулж байна. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурлын 22/02 дугаартай тогтоолоор компанийн хаяг болон бусад нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар шийдвэрлэсэн боловч эрх бүхий байгууллагаас дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлэхээс татгалзсаны улмаас хаягийн өөрчлөлтийг тусад нь бүртгүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн. Иймд Хувьцаа эзэмшигчдийн хурлын дээрх шийдвэрийг хүчингүй болгож, компанийн дүрэмд зөвхөн хаягийн өөрчлөлттэй холбоотой зохих өөрчлөлтийг оруулах саналыг гаргаж танилцуулж байна.

6 дугаар асуудал:

ТУЗ-ийн гишүүд сонгох тухай

Ч.Хашчулуун:

Компанийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусаж байгаа билээ. Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооноос ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх санал, хүсэлтийг хүлээн авч, бүртгэх үйл зохион байгуулсан. Ингэхдээ Компанийн саналын эрх бүхий хувьцааны 1 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид болон Монголбанк руу тус тус ТУЗ-ийн ердийн гишүүнд өөрийн төлөөллөөр 1 хүнийг нэр дэвшүүлэх талаарх санал авах тухай албан бичгийг хүргүүлж, саналыг 2024 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 17:00 цагаар тасалбар болгон хүлээн авч бүртгэх, Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтын зарыг 2-оос доошгүй олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон компанийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж, хүсэлтийг 2024 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 17:00 цагаар тасалбар болгон хүлээн авч бүртгэх үйл ажиллагааг зохион байгуулсан. Дээрх ажлын үр дүнг 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороогоор хэлэлцүүлж дүгнэлт гаргасан. Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны дүгнэлт, 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдөр, Дугаар№3, Улаанбаатар хот, Дүгнэлт

1. “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хуралд Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд дараах нэр дэвшигчдийг санал болгон нэр дэвшүүлэхийг дэмжив. Үүнд:

2.1. ТУЗ-ийн ердийн гишүүнд:

2.1.1. Ц.Байгалмаа, “Голомт банк” ХК-ийн төлөөлөл;

2.1.2. Т.Даваажав, “Худалдаа хөгжлийн банк” ХК-ийн төлөөлөл;

2.1.3. Д.Жадамбаа, “Төрийн банк” ХК-ийн төлөөлөл;

2.1.4. М.Мөнхбаатар, “Азиа дайверсифайд рийл эстэйт фанд нэг” ХХК-ийн төлөөлөл;

2.1.5. Б.Сайнзаяа, Монгол Улсын Хөгжлийн банкны төлөөлөл;

2.1.6. Н.Сэргэлэн, “Ти Ди Би секюритис ҮЦК” ХХК-ийн төлөөлөл;

2.1.7. Б.Үүрцайхбаатар, “Капитрон банк” ХК-ийн төлөөлөл;

2.1.8. А.Энхжин, Монголбанкны төлөөлөл

2.2. ТУЗ-ийн хараат бус гишүүнд:

1.2.1. А.Анар, “Синержи Фанд Солюшн ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал;

1.2.2. Д.Галхүү, “Лэндмн ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн;

1.2.3. Э.Шижир, Уул уурхай металлургын цогцолбор байгуулах төслийн удирдагч;

1.2.4. Ч.Хашчулуун, МУИС-ийн Дэд профессор;

1.2.5. О.Эрдэнэдалай, “Мелвилл Эрдэнэдалай” ХХН-ийн Гүйцэтгэх захирал.Эдгээр нэр дэвшигчдийн товч танилцуулгыг 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчид хүргүүлсэн материалын дагуу танилцуулав.

7 дугаар асуудал:

ТУЗ-ийн цалингийн зардлын төсвийг батлах тухай

Ч.Хашчулуун:

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны хурлаас“МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх цалингийн зардлын төсвийг нэмэхгүй өмнө жилтэй адил хэмжээтэй байххаар хэлэлцэж хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахаар шийдвэрлэсэн.

Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлууд танилцуулж дууслаа. Хурлын дэгийн дагуу хурлаар хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариултын цаг эхэлж байна.

Ч.Хашчулуун:

Асуулт хариултын цаг дууслаа. Хувьцаа эзэмшигчдээс асуулт ирээгүй байна. Өнөөдрийн хурлаас дараах тогтоолууд батлагдахаар байна. Тогтоолын төслийг 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчид хүргүүлсэн материалд туссан байдлаар уншиж танилцуулав. Мөн хурлын дэгийн дагуу санал хураалтын үйл ажиллагаа эхэлж байна.

Санал хураалт дууслаа. Санал хураалтын үр дүнг танилцуулахыг Тооллын комиссоос хүсэж байна.

Б.Болортуяа:

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай асуудалд: Нийт саналын эрхтэй 15,004,286 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 98.41 %-ийн ирцтэй оролцсон бөгөөд ирүүлсэн санал хураалтын нэгдсэн дүнгээр: Зөвшөөрсөн 15,004,286 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 100.00%, Түдгэлзсэн байхгүй. Татгалзсан байхгүй. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурлын 22/02 дугаартай тогтоолыг хүчингүй болгох тухай асуудалд: Нийт саналын эрхтэй 15,004,286 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 98.41 %-ийн ирцтэй оролцсон бөгөөд ирүүлсэн санал хураалтын нэгдсэн дүнгээр: Зөвшөөрсөн 15,004,286 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 100.00% Түдгэлзсэн, Татгалзсан байхгүй. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудалд: Нийт саналын эрхтэй 15,004,286 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 98.41 %-ийн ирцтэй оролцсон бөгөөд ирүүлсэн санал хураалтын нэгдсэн дүнгээр Зөвшөөрсөн 15,004,286 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 100.00% Түдгэлзсэн, Татгалзсан байхгүй. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай асуудалд Нийт 15,004,286 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 98.41 %-ийн ирцтэй оролцсон бөгөөд нийт 135,038,574 ширхэг саналын эрхтэй санал хураалтын нэгдсэн дүнгээр Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүд: Ц.Байгалмаа 9,213,291, Т.Даваажав 14,000,000, Д.Жадамбаа 4,382,559, М.Мөнхбаатар 17,000,000 Б.Сайнзаяа 27,737,595, Н.Сэргэлэн 12,881,577, Б.Үрцайхбаатар 11,661,999, А.Энхжин 15,409,997 Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд А.Анар 5,250,090, Д.Галхүү 0, Э.Шижир 7,590,000, Ч.Хашчулуун 9,661,466, О.Эрдэнэдалай 250,000 саналыг тус тус авсан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай асуудалд: Нийт саналын эрхтэй 15,004,286 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 98.41 %-ийн ирцтэй оролцсон бөгөөд ирүүлсэн санал хураалтын нэгдсэн дүнгээр Зөвшөөрсөн 15,004,286 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу 100.00%, Түдгэлзсэн, Татгалзсан байхгүй

Ч.Хашчулуун:

Тооллогын комисст баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас батлагдсан тогтоолыг танилцуулав. Та бүхэнд баярлалаа. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурал үүгээр өндөрлөж байна.

Шийдвэр, үүрэг даалгаврын томъёолол

Тогтоол-1

**“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

Дугаар №24/01

2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

**Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан
дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 4.8 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 24/06 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийн гаргасан 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА,**

гарын үсэг

Ч.ХАШЧУЛУУН

Тогтоол-2:

**“МИК ХОЛДИНГ” ХК-ийн
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

Дугаар №24/02

2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

Тогтоол хүчингүй болгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.15 дахь заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 4.13 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 24/07 дугаартай тогтоолын 2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурлын 22/02 дугаартай “Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг хүчингүй болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА

гарын үсэг

Тогтоол-3

**“МИК ХОЛДИНГ” ХК-ийн
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

Дугаар №24/03

2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

**Компанийн дүрэмд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай**

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 4.1 дэх заалт, 26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2-т “Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол /14210/, Энхтайваны өргөн чөлөө 19, 13-р давхар” гэснийг “Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу /15160/, Д.Сүхбаатарын талбай гудамж, 11 тоот” гэж өөрчилсүгэй.
2. Энэ тогтоолын 1-т заасан нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх, хаягийн өөрчлөлтийн талаар хувьцаа эзэмшигч, олон нийтэд мэдээлэх болон бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай.
3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА,

гарын үсэг

Ч.ХАШЧУЛУУН

Тогтоол-4

**“МИК ХОЛДИНГ” ХК-ийн
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

Дугаар №24/04

2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.7 дахь заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 4.7 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2024 оны 3 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**



1. Дараах нэр дэвшигчдийг “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр 3 жилийн хугацаатайгаар сонгосугай. Үүнд:
 - 1.1. Атарбаатарын Энхжин, Монголбанкны төлөөлөл ;
 - 1.2. Бат-Өлзийн Сайнзаяа, Монгол улсын хөгжлийн банкны төлөөлөл;
 - 1.3. Товуудоржийн Даваажав, Худалдаа хөгжлийн банкны төлөөлөл;
 - 1.4. М.Мөнхбаатар, “Азиа дайверсифайд рийл эстэйт фанд нэг” ХХК-ийн төлөөлөл;
 - 1.5. Н.Сэргэлэн, “Ти Ди Би секюритис ҮЦК” ХХК-ийн төлөөлөл;
 - 1.6. Б.Үүрцайхбаатар, “Капитрон банк” ХК-ийн төлөөлөл.
2. Дараах нэр дэвшигчдийг “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 3 жилийн хугацаатайгаар сонгосугай. Үүнд:
 - 2.1. Ч.Хашчулуун, МУИС-ийн Дэд профессор;
 - 2.2. А.Анар, “Синержи Фанд Солюшн ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал;
 - 2.3. Э.Шижир, Уул уурхай металлургын цогцолбор байгуулах төслийн удирдагч.
3. Энэ тогтоолын 1, 2-т зааснаар шийдвэрлэснийг Санхүүгийн зохицуулах хороонд болон арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан хувьцаа эзэмшигч, олон нийтэд тус тус мэдээлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.
4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА

гарын үсэг

Ч.ХАШЧУЛУУН

**“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

Дугаар №24/05

2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

Тогтоол-5

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн
цалингийн зардлын төсвийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 4.12 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2024 оны 4 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн

ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2024 оны 5 дугаар 01-ний өдрөөс 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх цалингийн зардлын төсвийг энэ тогтоолын Хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолын Хавсралтаар батлагдсан зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороонд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА,

гарын үсэг

Ч.ХАШЧУЛУУН

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ТУЗ-ийн дарга Г.Саруул



ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ДАРГА
Ч.ХАПЧУЛУУН

G. Saruul

Ch. Khamchuluun